

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ТОГТМОЛ ХЭВЛЭЛИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

П.Цэрэнням*

* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант, сэтгүүл зүйн магистр

Түлхүүр үг: хүүхдийн тогтмол хэвлэл, хүүхдийн сонин сэтгүүл, хүүхдийн хэвлэлийн үүрэг, хүүхдийн хэвлэлийн онцлог

1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгалын үрээр нийгмийн амьдралын бүх хүрээ, салбар өөрчлөгдөн шинэчлэгдэж, хөгжлийн шинэ замаар замнах, үйл ажиллагааны бүх хэлбэрийг шинээр зохион байгуулах шаардлага тулгарсан нь Монголын сэтгүүл зүйг ч тойрч өнгөрөөгүй юм. Аливаа өөрчлөлтөд хамгийн түрүүнд өртөж, шинэ сэргэг зүйлийг мэдрэх боломжоороо сэтгүүл зүй нийгмийн бусад институтээс давуу байдаг билээ. 1991 оноос хойш ХЗДХЯ-нд бүртгэгдсэн 1800 гаруй сонин хэвлэл байдгаас хүүхэд багачуудад зориулсан нь 80 гаруй байна¹. Тэдгээрээс одоо 10 орчим хэвлэл алдаг оног гарч байгаа юм. Хүүхдийн сонин, сэтгүүлүүд тэдний нас биеийн онцлог, хүсэл сонирхолд нийцсэн, эрдэм мэдлэг, гоо зүйн хүмүүжил, урлаг спортын сэдвээр төрөлжин гарах болов. «Манай орны хувьд хүүхдийн хэвлэл эхнээсээ л үзэл суртлын болон сурган хүмүүжүүлэх, гэгээрүүлэх

үүрэгтэй байсан бөгөөд харин ерээд оноос хойшх хүүхдийн хэвлэл сургалт, танин мэдэхүйн үүргийг илүүтэй гүйцэтгэх болсон онцлог бий»². Хүүхдийн сонинууд тэдний нас биеийн онцлог, хүсэл сонирхол, гоо зүйн хүмүүжил, урлаг спортын сэдвээр төрөлжин гарах болов. Ардчилал, олон ургальч үзэл нь ХМХ-ийн үйл ажиллагаа, нийтлэл нэвтрүүлэгт гол байр суурь эзлэх болсон бөгөөд сонин хэвлэлийн дотоод төрөл хэлбэр баяжин, үүнтэй уялдан хэвлэлийн эрх зүйн статуст өөрчлөлт орж, шинэ хэвшил, шинэ хэв маягууд бий болж эхэлсэн юм. Ингэснээр сонин хэвлэлийн тоо хэмжээ олширч, мэдээллийн чөлөөт өрсөлдөөнийг бий болгож мэдээллийн багтаамж, бичлэгийн арга барилд нөлөөлөхийн зэрэгцээ өөрийн онцлог, давуу тал нөөц боломжийг бүрэн ашиглах шаардлага урган гарч эхэлсэн юм.

"Сурлага", "Математик", "Сургуулийн математик" зэрэг сонин хүүхдийн сэтгэн бодох чадвар, логик ур сэтгэлгээ дээшлүүлэхэд чиглэсэн, "Би би би", "Цох", "Яагаад", "Симба" зэрэг сонин бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон, "Чиний зураг", "Супер", "Poster", "Free & Style" зэрэг сонин

гадаад дотоодын хамтлаг, дуучид, урлагийн оддын талаар дэлгэрэнгүй мэдээлсэн, "Нээлттэй сургууль", "Мөнхийн дуудлага", "Өглөө", "Гэрэлт ирээдүй", "Чиний хөтөч" зэрэг сонин шинжлэх ухаан, танин мэдэхүй, нийгмийн холбогдолтой сэдвийг чухалчилсан, "Үерхэл love", "Охид", "Өсвөр үе" зэрэг сонин гэр бүл, нөхөн үржихүй, гоо зүйн хүмүүжил, мэдлэг олгох, нийтлэлийн бодлого нь хүүхэд багачуудыг сонирхлын дагуу мэдээллээ олж авах өргөн боломжийг нээж өгч байгаа юм. Гэсэн хэдий ч нийтлэлийн бодлого, сэдэв давхардсан, мэдээллийн багтаамж, нийтлэлийн үр өгөөж багатай сонинууд ч элбэг байна. Хүүхдийн ихэнх сонинууд АЗ форматаар өнгөтөөр хэвлэгдэн гарч байна. Энд хүүхэд багачуудын шүтэн биширдэг хүмүүс, хамтлаг, дуучид, урлаг спортын алдартнуудын зургаар альбом хийсэн ч хангалтгай хүрэлцэхүйц гэрэл зургийг нийтэлж байгаа нь сонины зай талбайн ихэнх хэсгийг эзэлж байна. Мөн нэг сонин дээр гарсан материал нөгөө сонин дээр давтан гарах юм уу, эсвэл хэсэг хугацааны дараа дахин гарч байгаа зэрэг нь нийтлэлийн үр нөлөөг бууруулах сөрөг талтай юм. Эндээс хүүхдийн сонин хэвлэлийг эрхлэн гаргагчдын дотор мэргэжлийн сэтгүүлч боловсон хүчин цөөн, байсан ч редакцийн нэгдсэн бүтэц, зохион байгуулалтад ороогүй зэрэг хандлага ажиглагдаж байна. Хүүхдийн цөөнгүй сониныг бие даасан сэтгүүлч, уран бүтээлчид эрхлэн гаргаж байгаа юм. Редакцийн бүтэц, зохион байгуулалтад орсон, нэгдсэн бодлого, үйл ажиллагаа явуулж байсан сонины тоонд "Сурагч", "Би би би", "Сурагчийн мэдээ", "Үерхэл love", "Нээлттэй сургууль", "Сурлага", "Математик", "Мөнхийн дуудлага" зэрэг санхүүгийн бааз суурьтай, эсвэл ямар

нэгэн төсөл, хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг хэвлэл багтана.

"Би би би" сонин "Монгол ньюс", "Үерхэл love" Монгол улсын ЭМНХЯ, Маргарет Тетчерийн сан, "Гэрэлт ирээдүй", Хүүхдийн төлөө ТББ, Өсвөр үе-ЮНЕСКО, БСШУЯ-ны албан бус сургалт, төсөл зэргээс санхүүжүүлж байв.

«Хүүхдийн хэвлэлээс ашиг хонжоо олсон үйл ажиллагаа явуулах хэцүү болохоор мэргэжилтнүүд хүүхдийн хэвлэлийн салбар руу орж ажилладаггүй» гэж Оросын "СамоДелка" сэтгүүлийн эрхлэгч нэгэн ярилцлагадаа дурдсан байдаг.

1990-ээд оноос хойшх хүүхдийн хэвлэлүүдийн анхдагч нь Д.Батжаргал эрхлэгчтэй "Супер" сонин юм. Тус сонин 1992 онд "Монголын залуучууд" сонины дагуул сонин болж гарснаас хойш 2006 он хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байсан цорын ганц сонин байсан юм. "Супер" сонин сард нэг удаа гардаг байв.

“С урагч” сонин нь "Пионерийн үнэн", "Хойчийг залгамжлагч" сонины орыг залгасан томоохон сонины байр сууриа олон жил хадгалж байна. "Сурагч" сонин нь 2000-2005 онд Монголын олон уншигч захиалагчтай арван сонины тоонд тогтмол шалгарч байв. Хүүхдийн хэвлэлүүдээс анх түрүүнд азтай захиалагч шалгаруулж автомашин өгсөн нь менежментийн бодлогоо оновчтой тодорхойлж чадсаны илэрхийлэл болсон бөгөөд ингэснээр сонины захиалгын тоог өсгөх, оршин тогтнох нөхцөл боломжийг бүрдүүлж, анхны улирлын захиалгаараа 10 мянган захиалагчтай болж чадсан ажээ.

"Сурагчийн мэдээ" сонин нийтлэлийн бодлогын хувьд сургууль, анги хамт олныг сурталчлах, эргэх холбоо бүрдүүлэх, танин мэдэхүй чиглэлийн

мэдээллийг түлхүү нийтлэн гаргадаг байсны дээр найман нүүр өнгөт хүүхдийн анхны сонин байв.

"Симба", "Цох", "Яагаад" зэрэг цөөн сонины үйл ажиллагаа үүсэн бий болсноосоо хойш хэвийн явж байна. "Би би би" сониныг "Монгол ньюс" компани эрхлэн гаргадаг байсан нь хүүхдийн хэвлэл нь санхүүгийн бааз суурь, боловсон хүчин, редакцийн нэгдсэн бодлоготой байж оршин тогтдогийг харуулж байна. "Миний сонин"-ыг Азийн Хөгжлийн Банк санхүүжүүлдэг.

2000 оноос эхлэн хөдөө орон нутагт хүүхдийн сонин бий болж түүхийн хуудсаа баяжуулсан ололт, дэвшил мөн байв. Дорноговь аймгийн "Нутгийн хүүхдүүд", Налайхын "Оюуны элч", Эрдэнэтийн "Өглөө", Хэнтийн "Хүслийн өртөө" зэрэг сониныг нэрлэж болно. Өвөрмөц нийтлэлийн бодлоготой сонин ч байдаг. Жишээлбэл "Оюуны элч", "Хэлтэй бол хөлтэй" зэрэг хэвлэл нь хүүхдүүдэд зөвхөн гадаад хэлний мэдлэг олгоход чиглэгддэг. "Оюуны элч" сонин нь эх бичвэрийг дөрвөн улсын хэл дээр бичиж дүрэм тайлбар сэлтийг хийдэг. Мөн байгаль, ан амьтны сэдэвт "Жийв жийв" сониныг хүүхдийн зохиолч Ш.Дашдондог эрхлэн гаргаж байлаа.

Хүүхдийн бусад сонин хэвлэлийн тухайд үүсэн байгуулагдсанаас хойш дээд тал нь 3 жил, доод тал нь ганцхоёр дугаар гараад үйл ажиллагаа нь зогсдог гашуун туршлага хүүхдийн олон сониныг дайрсан юм.

Монголын хүүхдийн тогтмол хэвлэлийн онцгой нэгэн жишээ бол "National Geographic Kid's Mongolia" сэтгүүл байв. Уг сэтгүүл дэлхийн 188 оронд үйл ажиллагаагаа явуулдаг Үндэсний газарзүйн нийгэмлэгээс албан ёсны эрхтэйгээр Монгол улсад гарч байсан хүүхэдийн хэвлэл юм. Дэлхийн 5 сая гэр бүл сонгон уншиж, 19 оронд хэвлэгдэн гардаг, дэлхийн хэвлэлийн брэнд National Geographic Kid's сэтгүүлийг "Ирмүүн агентлаг"-аас монгол, англи хэлээр эрхлэн гаргаж байсан боловч нийт 16 дугаар гаргаснаар үйл ажиллагаагаа зогсоожээ.

Хялбаршуулсан, зугаатай байдлаар дэлхийн үүсэл, сансар огторгуй, хүрээлэн буй орчин, техник технологи, шинжлэх ухааны нээлтүүдийн тухай өгүүлдэг тус сэтгүүл

нь хүүхдийнхээ боловсрол, хөгжилд онцгой анхаардаг аав, ээжүүд, боловсролын байгууллагууд зорилтот уншигч, хэрэглэгч нь байснаараа онцлог байв. Хэдийгээр уг сэтгүүл цөөн дугаар гарсан ч гэсэн дэлхийн хүүхдийн хэвлэлийн жишгийг Монголын уншигч, хүүхэд багачуудад ойлгуулж мэдрүүлсэн, сонин хэвлэл эрхлэн гаргагчдад үлгэр дуурайл болохуйц үйл явц мөн байлаа.

Өнөөгийн хүүхдийн хэвлэлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлно гэдэг амаргүй хэрэг юм. Дал гаруй жилийн баялаг түүх, намтартай социалист сэтгүүл зүйн үеийн хүүхдийн хэвлэл, хорь гаруй жилийн хөгжилтэй чөлөөт ардчилсан сэтгүүл зүйн хүүх-

«

1990-ээд оноос хойших хүүхдийн хэвлэлүүдийн анхдагч нь Д.Батжаргал эрхлэгчтэй "Супер" сонин юм. Тус сонин 1992 онд "Монголын залуучууд" сонины дагуул сонин болж гарснаас хойш 2006 он хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байсан цорын ганц сонин байсан юм

»

дийн хэвлэл хоёрын хооронд зарчмын болоод чанарын асар их ялгаатай. 1990-ээд оноос хойш Монголд хүүхдийн хэвлэл хэр түвшинд хөгжсөн, ямар чиг баримтлалтай явж ирсэн бэ? гэдэг нь ойрын үнэн юм. Арав гаруй жилийн дотор хүүхдийн ная гаруй сонин, сэтгүүл гарснаас өнөөдөр уншигчдын гарт очиж байгаа нь арав хүрэхтэй үгүйтэй байгаа нь хүүхдийн хэвлэл хэр хөгжиж байгааг харуулна. Эдгээр сонинуудыг сэдэв чиглэлээр:

- сургалтын
- шинжлэх ухаан, танин мэдэхүйн
- эрүүл мэндийн
- энтертаймэнт
- гоо сайхны гэж ерөнхийд нь ангилж үзэж болохоор байна.

Уншигч хэрэглэгчиддээ зориулагдаж буй байдлаар:

- бага насныхны
- сургуулийн өмнөх насны
- сургуулийн бага, дунд насны
- ахлах ангийн буюу шилжилтийн насны гэж үзэж болох юм.

Гаралтын давтамж нь:

- 14 хоног
- сар
- улирлаар байна. Энэ нь ямар нэгэн шуурхай мэдээллийг онцолдоггүй болохыг мөн хүүхдүүдэд цаг үеийн шуурхай мэдээллийн сонин үгүйлэгдэж байгааг харуулж байна. Хүүхдийн хэвлэл хөгжихөд учирч буй томоохон бэрхшээл бол хөрөнгө санхүүгийн бололцоо хязгаарлагдмал байгаад оршино. Ихэнх сонин санхүүгийн бэрхшээлийн улмаас үйл ажиллагаагаа зогсоож байна. Үүнээс үүдэлтэй бас нэгэн сөрөг хүчин зүйл бол уншигч, захиалагчдыг татах, хадгалах сонины өрсөлдөөн буюу азтан тодруулах явдал байлаа. Сонины азтай уншигч, захиалагч тодруулна хэмээн сурталчилж хөрөнгө санхүүгийн ихэнх хэсгээ

буцааж зарцуулдаг энэхүү менежмент нь сонин оршин тогтноход сөрөг үр дагаврыг буй болгож байна. Сонинууд хөрөнгө санхүүгийн тодорхой хэсгээ уншигч захиалагчдаа татахад зориулж болох боловч шинээр гарч байгаа болон хөрөнгийн эх үүсвэр багатай сонинууд үүнд цохигдон захиалагчдаа алдан дампуурч байна. Үндсэндээ хэвлэлийн монополийн төлөөх ширүүн өрсөлдөөн явагдаж байгаа юм. Энэ өрсөлдөөнөөс үлдсэн сонин хэвлэлт, түгээлт, татвар болон редакцийн санхүүжилт зэрэгт үлдсэн орлогоо зарцуулна гэж тооцохоор цаашдаа тогтвор суурьшилтай үйл ажиллагаа явуулах боломжоо алдаж байгаа зэрэг хүчин зүйл түгээмэл байна. Хүүхдийн сонин манай улсад тогтвор суурьшилтай хөгжиж чадахгүй байгаа явдал нь доорх хүчин зүйлүүдээс шалтгаалж байна гэж үзэж байгаа юм.

Нэгд. Нийтлэлийн бодлого, сэдэв нь адил олон сонин байна.

Хоёрт. Хүүхдүүдэд өөрсдөд сониноо захиалах санхүүгийн боломж хязгаарлагдмал.

Гуравт. Хүүхдийн сонин ямар нэгэн нийгэм, улс төрийн үзэл бодлоос ангид, хов жив дуулиан шуугианы талаар бичиж мэдээлдэггүй болохоор бусад сонины адил байдаггүй.

Дөрөвт. Хүүхдийн сонин шуурхай бус, гаралтын давтамж зайтай.

Тавд. Телевиз болон цахим хуудас зэрэг мэдээллийн бусад хэрэгслээр хүүхдүүдийн хүсэл сонирхлыг татахуйц мэдээллийг илүү үр дүнтэй бодитой өгөх боломж өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа зэрэг шалтгаан байна гэж үзэж болох юм.

Монголын Хэвлэлийн Хүрээлэн 2012 оны 12-р сард улсын хэмжээнд хийсэн «ЕБС-ийн 7-11 дүгээр ангийн сурагчдын хэвлэл мэдээлэлтэй харилцах

суурь мэдлэг, ойлголтын түвшин, хэрэглээний онцлогийг тодруулах судалгаа»³-ны үр дүнг танилцуулсан. Тус судалгаагаар "...10-16 насны хүүхдүүд тогтмол хэвлэл уншиж хэвшээгүй, Интернет, телевиз зэрэг хэрэгслээс мэдээллээ авдаг, хүүхдийн сэтгэхүй, сонирхолд таарсан сонин, сэтгүүл үгүйлэгдэж байгаа, эцэг эхчүүд нь сонин сэтгүүл авч өгдөггүй, эсвэл хэт үнэтэй байдаг" болохыг тодорхойлжээ. Мөн «...орон нутгийн гурван сурагч тутмын нэг нь, Улаанбаатар хотын зургаан сурагч тутмын нэг нь "ардчилал, үг хэлэх эрх чөлөө" зэрэг ойлголтуудын талаар огт мэдлэггүй байсан нь анхаарал хандуулах зүйл мөн»⁴ гэж дүгнэсэн байна.

Нийт хүн амын 30 гаруй хувийг эзэлдэг хүүхэд багачуудын сонин хэвлэлийн асуудал, өдгөө хэвлэгдэн гарч буй цөөн хэдэн сонин хэвлэл нь сэтгүүл зүйн үүрэг, үр нөлөөг хангах түвшинд хүрч чадахгүй байгаад эрдэмтэн судлаачид шүүмжлэлтэй хандах болсон. МСНЭ, Д.Нацагдоржийн номын сантай хамтран "Монголын хүүхдийн хэвлэлийн өнөөгийн байдал" сэдэвт хэлэлцүүлгийг 2010 онд зохион байгуулсан юм.

«Сэтгүүлч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиуд хүүхдийн сэтгүүл зүйг хичээлийнхээ хөтөлбөрт тусгаж өгмөөр байна» гэж МСНЭ-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга асан Я.Сумьяа санал гаргаж байсан бол, ахмад сэтгүүлч Я.Арслан «Монгол Улсын хэмжээнд 716500 өрх 861700 хүүхэд бий гэсэн статистик бий. Тиймээс өрх бүрт хүүхдүүдийн хүмүүжилд тохирсон сонин хэвлэл үнэгүй тараах нь их үр дүнтэй юм болов уу... Хүн бүрт 70 мянган төгрөг тарааж болж байгаа юм чинь эх оронч үзэл, ёс зүй, эрүүл мэндийн мэдлэг гээд тэдний

хүмүүжилд нь тустай ганц ширхэг чанартай сониныг өрх бүрт тарааж болно. Хүүхдийн хэвлэл гарч байна. Тэд чанаргүйдээ биш юм. Хүүхдийн хэвлэлээр сенсаци хөөж болдоггүй болохоор л захиалагч цөөн байдаг» хэмээн шүүмжлэлтэй хандаж байсан бол, хүүхдийн зохиолч О.Сундуй «1990 оноос өмнө хүүхдийн хэвлэлийг төрөөс чиглүүлэн, санхүүжүүлж байсан. Харин зах зээлд шилжсэнээс хойш хувийн хэвшлийнхэн авч, чөлөөт өрсөлдөөний маягаар хөгжүүлж байна. Иймд төр засгаас хүүхдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд онцгой анхаарах цаг болсон» хэмээн дурдсан байдаг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн суурь харилцаа байдаг. Үүн дотроо хүүхдийн хэвлэл нь онцгойлон авч үзэх ёстой сэтгүүл зүйн салбар нэгж мөн учраас улсын хэмжээнд нэгдсэн бодлого шийдвэрээр зангидах цаг болсныг өнгөрсөн болон өнөө үеийн туршлага харуулж дараах дүгнэлтийг хийж байна.

Монгол оронд өрнөсөн ардчилсан хувьсгалт өөрчлөлтийн явцад хүүхдийн сонин хэвлэлийн үүрэг, зарчим өөрчлөгдөж, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн хувьд доголдох болсноор Монголын хүүхэд багачуудын нийтээр унших сонин хэвлэлийн орон зай үгүй болж, цогц бодлого алдагдсан.

1990-ээд оны дунд үеэс эхлэн хүүхдийн сонин хэвлэл шинээр үүсэн бий болж эхэлсэн. Энэ нь нийтлэлийн бодлого, сэдэв учир дутагдалтай, хамрах цар хүрээ бага, мөнгөний хойноос хөөцөлдсөн, хүүхдийн сониноор бизнес хийх гэсэн оролдлого ихээр гарч, энэ нь амжилтад хүрэх нь ховор байв.

Сонин хэвлэлийн захиалгад урамшуулал, амлалт өгөх менежментийн үйлдэл хэрээс хэтэрч, энэ нь эргээд

сонины оршин тогтоход сөргөөр нөлөөлсөн хүчин зүйл болсон байна.

Хүүхдийн ихэнх сонин, сэтгүүл өнгөт нүүрээр, цөөн тоогоор хэвлэгдэн гарч байгаа болон цаасны үнийн өсөлт, хэвлэлийн өндөр технологи шаардсан бүтээгдэхүүний нэгж өртөг их, хөдөө орон нутагт хүргэх шуудан үйлчилгээний зардал өссөн зэрэг нь хэвлэл захиалгад нөлөөлж байна.

Хүүхдийн сонин хэвлэлийн төвлөрөл Улаанбаатар хотод бий болж, хөдөө орон нутгийн хүүхэд багачуудад хүрч үйлчилж чадахгүй байгаа нь улсын хэмжээний цар хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг эдийн засаг, статусын хувьд бие дааж бэхжсэн сонин хэрэгтэй байгааг харуулж байна.

Цаашид хүүхдийн сонин хэвлэл нь сэдэв төрлийн хувьд улам нарийсч хүүхдийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд тулгуурласан давтамж ойр, мэдээллийн багтаамж сайтай, хамрах хүрээгээ өргөсгөвөл хөгжих боломжтой гэж үзэж байна.

Хүүхэд, өсвөр үеийнхний мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хүндэтгэх, олон нийтийн мэдээллийн харилцаанд хүүхдийн оролцоог хангахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэлийн бодлого, нэвтрүүлгийн хөтөлбөрт эзлэх хүүхдийн (оролцооны) нийтлэл, нэвтрүүлгийн зохистой хэмжээг тогтоож өгөх зэрэг зохион байгуулалтын болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал цаг үеийн шаардлагаар тавигдаж байна.

Ишлэл

¹ ХЗДХЯ болон УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын сонин сэтгүүлийн бүртгэл (1991-2015 он).

² 2015. Монголын сэтгүүл зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд // Сэтгүүл зүй судлаачдын үндэсний 3-р дугаар симпозиумын илтгэлийн эмхэтгэл. УБ., 79-82 дахь тал.

³ 2012. ЕБС-ийн 7-11 дүгээр ангийн сурагчдын хэвлэл мэдээлэлтэй харилцах суурь мэдлэг, ойлголтын түвшин, хэрэглээний онцлогийг тодруулах судалгааны тайлан. МХХ. УБ.

⁴ Мөн тэнд.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. ХЗДХЯ болон УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын сонин, сэтгүүлийн бүртгэл (1991-2015 он).

2. 2015. Монголын сэтгүүл зүйн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд // Сэтгүүл зүй судлаачдын үндэсний 3-р дугаар симпозиумын илтгэлийн эмхэтгэл. УБ., 79-82 дахь тал.

3. 2012. ЕБС-ийн 7-11 дүгээр ангийн сурагчдын хэвлэл мэдээлэлтэй харилцах суурь мэдлэг, ойлголтын түвшин, хэрэглээний онцлогийг тодруулах судалгааны тайлан. МХХ. УБ.

4. *Зулькафиль М.* 2011. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.

5. *Зулькафиль М.* 2011. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг намын үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.

6. *Норовсүрэн Л.* 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

Summary

Since 1990, study on press conditions for children in democratic journalism would enable to conclude development process for future development. The media is the fundamental of social relations. Hereof, children journalism is the area, needed to take special consideration, and perhaps it's time to have integrated as well as combined approach on this field due to our past and present experience. In order to respect the legitimate rights children on information freedom and enable social involvement of children, there are certain demands to improve legal regulation, media policy for children, children involvement and publication in broadcasting.